МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр Дугаар А/139 Мөрөн сум

Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны даргын ажлын байрны шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Р.Машбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд: Г.Нарангэрэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Отгончимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Г.Галтболд (Аймгийн Соёл урлагийн газрын мэргэжилтэн)

М.Одмаа (Аймгийн Төв музейн Эрдэм шинжилгээний ажилтан)

Нарийн бичгийн дарга:

Ц.Баасанжав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2.Аймгийн Төв музейн захирлын ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, төслийг Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлд хянуулахыг ажлын хэсгийн ахлагч (Р.Машбат)-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

6712010254